

НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ ГАРГАГЧИЙН АНКЕТ

д/д	Шалгуур үзүүлэлт	Мэдээлэл
1	Нэр Овог, эцэг, эхийн нэр, өөрийн нэр, нэрээ өөрчилж байсан бол өмнө нь хэрэглэж байсан нэр	Шаравнямбуу Цогбаатар
2	Хүсэлт гаргагчийн хаяг Иргэний үнэмлэхэд байгаа хаяг	
3	Төрсөн огноо Төрсөн газар	
4	Боловсрол Дээд боловсрол эзэмшсэн сургууль тус бүрийг сүүлд төгссөн сургуулиас нь эхлэн жагсаан бичнэ. Сургууль тус бүрд суралцсан хугацаа, авсан зэрэг, огноог бичнэ.	<ul style="list-style-type: none"> ➤ 2002-2004 онд Оросын холбооны улсын Дотоод явдлын яамны Удирдлагын академи- хууль зүйн ухаан магистр, ➤ 1990-1994 онд Цагдаагийн дээд сургууль- бакалавр
5	Ажил эрхлэлт Их, дээд сургууль төгссөнөөс хойш ажилласан төрийн байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага болон бусад байгууллагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсаан бичнэ. Ажил олгогчийн нэр, хаяг, утас, цахим болон ажлын байрны нэрийг бичнэ.	<ul style="list-style-type: none"> ➤ 2018 оны 01 дүгээр сарын 17-ноос одоог хүртэл Нийслэлийн цагдаагийн удирдах газрын дэд бөгөөд Мөрдөн шалгах газрын дарга ➤ 2014-2018 онд Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтсийн дарга, ➤ 2008-2014 онд Эрүүгийн цагдаагийн газрын Онц хүнд гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн дарга, ➤ 2004-2008 онд Эрүүгийн цагдаагийн газрын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн дарга, ➤ 2002-2004 онд ОХУ-ын Дотоод явдлын яамны удирдлагын академид сонсогч, ➤ 1999-2002 онд Эрүүгийн цагдаагийн газрын Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн чиглэлийн ахлах төлөөлөгч, ➤ 1996-1999 онд Нийслэлийн прокурорын газарт хяналтын прокурор, ➤ 1993-1996 онд Баянзүрх дүүргийн цагдаагийн хэлтэст эрүүгийн төлөөлөгч
6	Нэр дэвших тухай хүсэлт гаргасан албан тушаал Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн эсхүл Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний алинд нэр дэвшиж байгаа талаар бичнэ.	Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн
7	Эрх зүйч мэргэжлээр эрхэлсэн ажил: Хүсэлт гаргагч эрх зүйч мэргэжлээр сүүлийн арваас доошгүй жил эрхэлсэн ажлыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ. - Албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа - Ажлын байрны тодорхойлолт - Удирдах албан тушаалтны нэр, холбоо	<ul style="list-style-type: none"> ➤ 2018 оны 01 дүгээр сарын 17-ноос одоог хүртэл Нийслэлийн цагдаагийн удирдах газрын дэд бөгөөд Мөрдөн шалгах газрын дарга ➤ 2014-2018 онд Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтсийн даргаар, ➤ 2008-2014 онд Эрүүгийн цагдаагийн газрын Онц хүнд гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн дарга, ➤ 2004-2008 онд Эрүүгийн цагдаагийн газрын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн дарга ➤ 2002-2004 онд ОХУ-ын Дотоод явдлын яамны удирдлагын академид сонсогч, ➤ 1999-2002 онд Эрүүгийн цагдаагийн газрын Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн чиглэлийн ахлах төлөөлөгч, ➤ 1996-1999 онд Нийслэлийн прокурорын газарт хяналтын прокурор,

	<p>барих мэдээлэл</p> <ul style="list-style-type: none"> - Хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл 	<p>➤ 1993-1996 онд Баянзүрх дүүргийн цагдаагийн хэлтэст эрүүгийн төлөөлөгч</p>
8	<p>Ёс зүй</p> <p>Доор дурдсан асуудлыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, түүний гол агуулгыг тодорхойлно.</p> <ul style="list-style-type: none"> - сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж байсан эсэх - сүүлийн таван жилд улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байсан эсэх 	<p>Сахилгын шийтгэл хүлээж байгаагүй.</p> <p>Сүүлийн 5 жилд улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхлээгүй.</p>
9	<p>Хууль зүйн өндөр мэдлэг, чадвар</p> <p>Хүсэлт гаргагчийг хууль зүйн өндөр мэдлэг, чадвартай гэдгийг нотлон харуулах хамгийн чухал 10 мэргэжлийн үйл ажиллагааг хамгийн сүүлчийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ.</p> <ul style="list-style-type: none"> - Үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа - Үйл ажиллагааны гол агуулга - Үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ - Үйл ажиллагааг удирдсан албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл - Хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл - Хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар 	<p>Нийслэлийн цагдаагийн удирдах газрын харьяа дүүрэг дэх цагдаагийн хэлтсүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, мөрдөн шалгах ажиллагаа удаашралтай явагдаж байгаа олон үйлдэл холбогдогчтой ээдрээ төвөгтэй эрүүгийн хэргүүдийг түргэн шуурхай шийдвэрлэх, дүүрэг дэх цагдаагийн хэлтсүүдэд мэргэжил арга зүйн дэмжлэг тусалцаа үзүүлэх чиглэлээр ажилладаг.</p> <p>1. 2020 оны 1 дүгээр улиралд - Нийслэл хотын хэмжээнд үйлдэгдсэн хүний амь нас хохирсон, дээрэмдэх, хохирол ихтэй эд зүйл алдсан хулгайлах хэргийн газрын үзлэг, мөрдөн шалгах ажиллагаанд 25 удаа оролцож, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хэргийн шийдвэрлэлтийг ахиулах чиглэлээр 10 удаа нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж ажилласанаар нийслэлд бүртгэгдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 1406 нэгж буюу -21.1 хувиар буурч, гэмт хэргийн илрүүлэлт 28.4 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12.1 хувиар өссөн.</p> <p>Эзэн холбогдогч нь тогтоогдоогүй хэргийг илрүүлэх, хэргийн шийдвэрлэлтийг ахиулах, алба хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх чиглэлээр “Эрэн сурвалжлалт-шийдвэрлэлт” хэсэгчилсэн арга хэмжээг Сүхбаатар, Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн хэлтсүүдэд зохион байгуулсан нь үр дүнгээ өгсөн. Хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд Нийслэлийн прокурорын газар, дүүргийн прокурорын газрын удирдлага болон хяналтын прокуроруудтай уулзалт зохион байгуулж, Сүхбаатар дүүрэг дэх цагдаагийн хоёрдугаар хэлтсийн 142, Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтсийн 407, Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн газрын 950 хэргийг тус тус шийдвэрлэсэн.</p> <p>2. 2019 онд дүүрэг дэх цагдаагийн хэлтсүүдийн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн хүнийг алах, дээрэмдэх, бага насны хүүхдийг хүчиндэх, бусдын орон байранд нэвтэрч их хэмжээний хохирол учруулсан хулгайлах болон бусад ноцтой хэрэг үйлдэгдсэн тохиолдол бүрт хэргийн газарт ажиллаж мэргэжлийн удирдлагаар ханган мэдээ, мэдээлэл солилцон хамтран ажилласанаар 2019 онд гэмт хэргийн илрүүлэлт 38.9 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.1 хувиар өссөн. Үүнээс: Хүнийг алах гэмт хэргийн илрүүлэлт 97, дээрэмдэх 37,2, хүчиндэх 47,2, хулгайлах 23,5 хувьтай, урьд оны мөн үеэс 2,8-18,5 хувиар тус тус өссөн.</p> <p>3. Нийтийн байр түрээслэх чиглэлээр бизнесийн үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн аж ахуйн нэгж байгууллагуудыг бүртгэн зөвшөөрөл олгодог, хяналт тавьдаг, эрх зүйн орчинг бүрдүүлэх</p>

саналыг Нийслэлийн засаг даргын тамгын газарт хүргүүлсэнээр “Нийтийн байр хөлслөх чиглэлээр бизнесийн үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагын ашгийн зорилгоор нийтийн байрыг хөлслөх үйлчилгээ эрхлэхэд дагаж мөрдөх нийтлэг журам”-ын төслийг боловсруулах ажлын хэсэг НЗД-ын 2019 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн А/457 дугаартай захирамжаар байгуулагдсан. Уг ажлын хэсэг журмын төслийг боловсруулан, хянуулж Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар 2019 оны 10 дугаар сарын 08-ны өдөр Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан.

4. 2018 онд гэмт хэргийн илрүүлэлтийг ахиулах, мөрдөн шалгах ажлын үр дүнг нэмэгдүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг 25 удаа зохион байгуулж, арга хэмжээний хүрээнд дүүрэг дэх цагдаагийн хэлтсүүдэд мэргэжил арга зүйн туслалцаа дэмжлэг үзүүлэн ажиллаж, нийт 4084 хэргийг шийдвэрлэж, 2244 хэргийг илрүүлж, 1392 оргодол, сэжигтэн этгээд, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээдийг эрэн сурвалжлан баривчилж, 986 сая төгрөгийн нуугдмал хөрөнгийг илрүүлж холбогдох албанд шилжүүлж, 856,8 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж ажилласан.

5. Нийслэлийн дүүргүүд дэх цагдаагийн хэлтсүүдийн хэсгийн байцаагч нарын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийг халуун мөрөөр нь илрүүлэх, таслан зогсоох чиглэлээр хийж байгаа ажилд дэмжлэг үзүүлэн ажлыг эрчимжүүлэх зорилгоор “Хэсгийн байцаагч” хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж, дүүрэг дэх цагдаагийн хэлтсүүдийн нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга 12, ахлах байцаагч 5, хэсгийн байцаагч 123, нийт 140 алба хаагчдад 2 удаагийн сургалтыг зохион байгуулж, 5 заалт бүхий үүрэг ажлын чиглэлийг хүргүүлэн үр дүнг тооцсон.

6. Баянзүрх дүүргийн цагдаагийн 1, 2 дугаар хэлтсийн нутаг дэвсгэрт бусдын эд зүйлийг дээрэмдэх гэмт хэргийн нөхцөл байдал хүндэрч, илрүүлэлт буурсантай холбоотойгоор “Дээрэм” арга хэмжээг 14 хоногийн хугацаатай зохион байгуулж, Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтсийн 41, цагдаагийн хоёрдугаар хэлтсийн 80 хэрэгт мэдээ, мэдээлэл солилцон ажиллаж, эзэн холбогдогч нь тогтоогдоогүй 24 хэргүүдийг илрүүлэн, эрэн сурвалжлагдаж байгаа болон гэмт хэрэгт сэрдэгдсэн оргодол 19 этгээдүүдийг эрэн сурвалжлан олж тогтоосоноор Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтсийн дээрэмдэх гэмт хэргийн илрүүлэлт 13,5%, Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн хоёрдугаар хэлтсийн дээрэмдэх гэмт хэргийн илрүүлэлт 16,1% хувиар тус тус нэмэгдсэн үр дүн гарсан.

7. “Залилах” хэргийн шийдвэрлэлт нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж, дүүргүүд дэх цагдаагийн газруудын мөрдөгч, дүүргүүд дэх прокурорын газрын хяналтын прокуроруудад 5 хоногийн хугацаатай “Залилах гэмт хэргийг иргэний хэргээс хэрхэн ялгах, энэ төрлийн гэмт хэргийг шалгахад анхаарах асуудал” сэдэвт сургалтыг Улсын ерөнхий прокурорын газрын сургалт судалгааны төвтэй хамтран зохион байгуулсан нь хэргийн шийдвэрлэлтэд нөлөөлсөн үр дүнтэй ажил болсон.

Нийслэлийн дүүргүүд дэх цагдаагийн газруудад 2019 оны 09 дүгээр сарын 25-ний өдрийн байдлаар залилах 5085 гэмт хэрэг бүртгэгдэн шалгагдаж байснаас 3185 хэрэг буюу нийт хэргийн 62,6 хувийг нь шийдвэрлэсэнээр 2019 оны 11 дүгээр сарын 25-ний өдрийн байдлаар залилах хэргийн илрүүлэлт 32,3 хувьтай байгаа нь урд оны мөн үеэс 10,5 хувиар өссөн үзүүлэлттэй гарсан.

		<p>8. Стандартчилал, хэмжил зүйн үндэсний зөвлөлд хүсэлт тавьж, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/231 дүгээр тушаалаар ХЗДХЯ-ны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Цагдаагийн ерөнхий газар, Нийслэлийн цагдаагийн газар, Татварын ерөнхий газар, Санхүүгийн зохицуулах хороо, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын төлөөлөл орсон ажлын хэсэг байгуулагдаж, “Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ. Нийтлэг шаардлага MNS 5274:2017” стандартыг шинэчлэн боловсруулан Зөвлөлийн 2017 оны 10 дугаар сарын 19-ны өдрийн 35 дугаар тогтоолоор батлуулан, стандартыг 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдүүлж эхэлсэн.</p> <p>Цагдаагийн байгууллагын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлж, хуулиар хүлээсэн үүрэгт ажлаа нэр төртэй биелүүлж, иргэд, олон нийтийн амар тайван амьдрах нөхцөл бололцоог бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулсан, ард иргэд болон цагдаагийн байгууллага, хамт олныхоо итгэл хүндэтгэл хүлээсэн, цагдаагийн алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлдэг, аливаа асуудалд шударга ханддаг, зарчимч, хариуцлага өндөртэй, эрхэлсэн ажилдаа эзний ёсоор ханддаг, шинийг эрэлхийлж үйл ажиллагаандаа хэрэгжүүлэхийг зорьдог, бүтээлч санаачлагатай, хамт олныг удирдан зохион байгуулах чадвартай, цагдаагийн үйлчилгээг иргэд, олон нийтэд түргэн шуурхай хүргэх, иргэд, байгууллагаас гаргасан гомдол мэдээлэл, санал хүсэлтийг хуулийн хугацаанд шалган шийдвэрлэх ажлыг дээшлүүлэх, хуульч шуурхай ажиллагааг хангах чиглэлээр идэвх зүтгэл, гаргаж хүнд, бүлэг, зохион байгуулалттай гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулахад мэргэшсэн, 2017 онд Нийслэлийн цагдаагийн удирдах газрын “Тэргүүний удирдах ажилтан”, 2018 онд Цагдаагийн ерөнхий газрын “Тэргүүний удирдах ажилтан”-аар шагнагдсан.</p>
2	<p>Хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах чиглэлээр эрхэлсэн ажил</p> <p>Хүсэлт гаргагч хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах чиглэлээр сүүлийн таваас доошгүй жил эрхэлсэн ажлыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ.</p> <ul style="list-style-type: none"> - Албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа - Ажлын байрны тодорхойлолт - Удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл - Хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл 	<ul style="list-style-type: none"> ➢ 2018 оны 01 дүгээр сарын 17-ноос одоог хүртэл Нийслэлийн цагдаагийн удирдах газрын дэд бөгөөд Мөрдөн шалгах газрын дарга ➢ 2014-2018 онд Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтсийн даргаар,
11	<p>Хүний эрхийг хүндэлж, дээдэлдэг байдал</p> <p>Хүсэлт гаргагчийн хүний эрхийн мэдлэг, чадвар, хүний эрхийг хүндэтгэж, дээдэлдэг гэдгийг нотлон харуулах хамгийн чухал 10 үйл ажиллагааг сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ.</p> <ul style="list-style-type: none"> - Үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, 	<p>Алба хаагчдынхаа үйл ажиллагаанд хяналт тавьж, иргэдтэй зөв боловсон харьцах, эрүүдэн шүүх, бусад хэлбэрээр иргэдтэй зүй бус харьцахгүй байх талаар үүрэг чиглэл өгч ажилласанаар алба хаагчдаас бусдад эрүү шүүлт тулгасан, иргэдтэй зүй бус харьцсан талаар гомдол ирээгүй.</p> <p>Алба хаагчдынхаа мэдлэг, чадварыг дээшлүүлэх, өөрийгөө хөгжүүлэх чиглэлд анхаарч, дэмжлэг үзүүлэн төрийн болон төрийн бус байгууллагуудаас болон дотооддоо хүний эрхийн чиглэлээр зохион байгуулсан 4 удаагийн сургалтуудад 77 алба хаагчдыг хамруулсан.</p> <p>Орхон их сургуультай гэрээ байгуулан тус газрын 25 алба хаагчдыг магистрын сургалтанд</p>

<p>хугацаа</p> <ul style="list-style-type: none"> - Үйл ажиллагааны гол агуулга - Үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ - Үйл ажиллагааг удирдсан албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл - Хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл - Хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар 	<p>хамруулж, амжилттай төгссөн.</p> <p>Цагдан хоригдсон 257 сэжигтэн, яллагдагч нартай мөрдөгч 10 хоног, мөрдөн байцаах тасгийн дарга 21 хоног тутамд уулзаж, тэдний санал хүсэлтийг хүлээн авч, тухай бүр нь шийдвэрлэж ажилласан. Дээрх иргэдээс эрх зөрчигдсөн, эрүүдэн шүүлт тулгасан, мөн цагдан хоригдсон хугацаа хэт урт байсан талаар гомдол санал гаргаагүй.</p> <p>Авлигын эсрэг хууль, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх, энэ чиглэлээр зохион байгуулж буй ажил, арга хэмжээг иргэд, олон нийтэд сурталчлах зорилгоор самбар гаргаж, иргэдийн санал, хүсэлтийг авах хайрцагыг ажиллуулж байгаа бөгөөд одоогоор иргэдээс дээрх чиглэлээр санал ирээгүй байна.</p> <p>Иргэдэд цагдаагийн байгууллагын үйлчилгээг шуурхай хүргэх зорилгоор жижүүрийн офицер, цагдааг 24 цагаар үүрэг гүйцэтгүүлж, газар, хэлтсийн дарга нараас иргэдэд ямар нэгэн хүндрэл учруулахгүйгээр цаг тухай бүрт нь хүлээн авч уулзаж, санал хүсэлтийг сонсон ажилладаг.</p> <p>Гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн эрх ашгийг хамгаалах, бүртгэгдсэн хэргийг шуурхай шалгаж шийдвэрлэх чиглэлээр дүүрэг дэх цагдаагийн газар, хэлтсийн дарга нарт 2018 онд 4 удаа, 2019 онд 3 удаа, 2020 оны эхний 1 дүгээр улирлын байдлаар 2 удаагийн үүрэг чиглэл хүргүүлсэн.</p> <p>Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх, өмгөөлүүлэх эрхээр хангах асуудлаар Хуульчдын холбоо, Өмгөөлөгчдийн холбоотой хамтран ажиллах талаар алба хаагчдад мэдээллийг хүргэж, төлбөрийн чадваргүй 87 сэжигтний эрх ашгийг хангуулахаар холбогдох журмын дагуу Хууль зүйн туслалцааны төвд хандан өмгөөлөгч томилуулж ажилласан.</p> <p>Нийслэлийн цагдаагийн удирдах газрын харьяа дүүргүүд дэх цагдаагийн газар хэлтсийн мөрдөн шалгах эрх бүхий алба хаагчдаас хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулахдаа хэргийн оролцогч нарт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулинд заасан эрхийг тайлбарлаж өгдөггүй, мэдүүлэг авахаар албадах, айлган сүрдүүлэх, зүй бус үг хэллэг хэрэглэж эрүүдэн шүүх хэлбэр таслан зогсоогдохгүй байна.</p> <p>2019 онд Улсын хэмжээнд гэмт хэргийн талаарх 60765 гомдол мэдээлэл хүлээн авснаас 155 буюу 0,2 хувь нь эрүүдэн шүүхтэй холбоотой гомдол мэдээлэл байх бөгөөд дээрх гомдол мэдээллийн 88 буюу 56,7 хувийг гэмт хэргийн шинжгүй гэх үндэслэлээр хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж шийдвэрлэсэн, 52 буюу 33,5 хувьд нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээж шалгаснаас 32 буюу 62,5 хувийг нь гэмт хэргийн шинжгүй тухайн хэргийг урд нь шийдвэрлэсэн шийдвэр хүчинтэй байгаа гэх үндэслэлээр хааж, 2 хэрэгт прокурорын байгууллагас яллах дүгнэлт үйлдэж шүүхэд шилүүлэн шийдвэрлэсэн байна.</p> <p>Цагдаагийн байгууллагын алба хаагчдыг эрүү шүүлтээс ангид байж хүний эрхийг дээдэлж хууль, журмыг мөрдөж ажиллуулах чиглэлээр доорх ажлыг зохион байгуулсан. Үүнд</p> <p>Монгол улсын хүний эрхийн үндэсний комиссоос гаргасан Хүний эрх ба эрүү шүүлт номыг нийт алба хаагчдад уншиж судлуулах, сургалт зохион байгуулсан.</p> <p>Мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий мөрдөгч нар хэрэг бүртгэх мөрдөн шалгах ажиллагаанд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг хэрэглэж байгаа байдал, алдаа дутагдалд дүгнэлт өгч шинэ залуу алба хаагчдыг сурган дадлагажуулах чиглэлээр сургалт зохион байгуулсан.</p> <p>Эрүү шүүлтийн өнөөгийн нөхцөл байдал, Эрүү шүүлтээс ангид байх эрхийн хэрэгжилт, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны талаар мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий алба хаагчдын мэдлэг ур чадварыг дээлшүүлэх зорилгоор зохион байгуулсан сургалт, сурталчилгааны арга хэмжээнд нийт 269 алба хаагчид, удирдах ажилтан нарыг бүрэн хамруулжээ.</p> <p>Дээрх ажил арга хэмжээг зохион байгуулж ажилласнаар мөрдөн шалгах газрын алба</p>
---	---

12	<p>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны туршлагын талаар: Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан гишүүний албан тушаалд нэр дэвших тухай хүсэлт гаргагч нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мөрдөгч, өмгөөлөгч, прокурор, шүүгчээр ажиллаж байсан бол тэдгээрийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ.</p> <ul style="list-style-type: none"> - Албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа - Ажлын байрны тодорхойлолт - Удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл - Хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл 	<p>хаагчдаас 2015 оноос хойш хугацаанд хүний эрх зөрчсөн бусадтай хүнлэг бус харьцсан эрүүдэн шүүсэн зөрчил дутагдал гаргаагүй байна.</p> <ul style="list-style-type: none"> ➢ 1999-2002 онд Эрүүгийн цагдаагийн газрын Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн чиглэлийн ахлах төлөөлөгч, ➢ 1996-1999 онд Нийслэлийн прокурорын газарт хяналтын прокурор, ➢ 1993-1996 онд Баянзүрх дүүргийн цагдаагийн хэлтэст эрүүгийн төлөөлөгч <p>2018 онд Улсын хэмжээнд 36220 гэмт хэрэг үйлдэгдсэний 25652 буюу 70.8 хувь нь Нийслэлд бүртгэгдсэн байна. Нийслэлд бүртгэгдсэн 25652 гэмт хэргийн өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3705 хэргээр буюу 16.9 хувиар өссөн. Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 24955 буюу 97.2 хувь нь хэрэг бүртгэлтийн хэрэг, илрүүлэлт 28.8 хувьтай, 697 буюу 2.7 хувь нь мөрдөн байцаалтын хэрэг бүртгэгджээ. Гэмт хэргийн илрүүлэлт 28.8 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеийн төвшинд байна.</p> <p>2019 онд Улсын хэмжээнд 31524 гэмт хэрэг үйлдэгдсэний 20261 буюу 64.3 хувь нь Нийслэлд бүртгэгдсэн байна. Нийслэлд бүртгэгдсэн 20261 гэмт хэргийн өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5391 хэргээр буюу 21.0 хувиар буурсан. гэмт хэргийн илрүүлэлт 38.9 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.1 хувиар өссөн байна.</p> <p>2020 оны 1 дүгээр улиралд 8003 гэмт хэрэг бүртгэгдсэний 5260 буюу 65.7 хувь нь Нийслэлд үйлдэгдсэн. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад -1406 хэргээр буюу -21.1 хувиар буурсан. гэмт хэргийн илрүүлэлт 28.4 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12.1 хувиар өссөн байна.</p> <p>2020 оны эхний 1 дүгээр улирлын байдлаар Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Мөрдөн шалгах газрын алба хаагчид иргэд байгууллагаас ирүүлсэн урьд онд болон энэ онд үйлдэгдсэн 471,3 сая төгрөгний хохиролтой, 435 хэргийг илрүүлж, ASAP санд эрэн сурвалжлагдаж байсан 54 этгээдийг олж тогтоон, хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын 323 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулан, 107 хэргийг шийдвэрлэж ажилласан байна.</p> <p>2019 онд нийт 700 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулсанаас шүүхэд шилжүүлэх саналтай 165, хэрэгсэхгүй болгох саналтай 137, нэгтгэсэн 137, харьяаллаар 4, нийт 443 хэргийг шийдвэрлэсэн. Шалгасан хэрэг 197 хэрэг буюу 39,1 хувиар өссөн байна. 2019 онд нийслэлд урьд онд болон энэ онд үйлдэгдээд эзэн холбогдогч нь тогтоогдоогүй нийт 922 этгээдэд холбогдох 3,7 тэрбум төгрөгний хохиролтой, 2209 гэмт хэргийг илрүүлж ажилласан нь урьд онтой харьцуулахад 35,2 хувиар өссөн.</p> <p>2018 онд тус газрын алба хаагчид тайлангийн хугацаанд 1,265,000,000 сая төгрөгний хохиролтой, 386 холбогдогчтой, 578 материалыг харьяаллын дагуу шилжүүлж, урьд онд болон энэ онд үйлдэгдээд эзэн холбогдогч нь тогтоогдоогүй нийт 1160 этгээдэд холбогдох 1355,8 сая төгрөгний хохиролтой, 1480 гэмт хэргийг илрүүлж, ASAP сангаар эрэн сурвалжлагдаж байсан 109 этгээдийг олж тогтоож, 986 сая төгрөгийн нуугдмал хөрөнгийг илрүүлж холбогдох албанд шилжүүлж, 856,8 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, иргэд аж ахуйн нэгж байгууллагаас гэмт хэргийн шинжтэй нийт 238 гомдол, мэдээлэл хүлээн авсанаас гэмт хэргийн шинжтэй 206, зөрчлийн шинжтэй 32 гомдол мэдээлэл байна. Нийт гомдол мэдээллийн 225 буюу 94,5 хувийг шийдвэрлэсэн.</p> <p>Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг нэг мөр хэрэгжүүлэх чиглэлээр алба хаагчдад практик болон танхимын сургалтыг сард 2-с доошгүй удаа зохион</p>
----	---	--

		байгуулж ажилласнаар тус газрын алба хаагчдаас 2012 оноос хойш Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжийг зөрчсөн талаар Шүүхийн магадлал, прокурорын шаардлага, хариуцлага тооцох албан бичиг аваагүй байна.
13	<p>Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүнчлэлийн талаар:</p> <p>Монголын хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, хууль зүйн эсхүл хүний эрхийн бусад холбоо, байгууллагад гишүүн бол нэрлэн бичнэ.</p> <ul style="list-style-type: none"> - Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүн болсон огноог бичнэ. Уг байгууллагын гишүүнчлэлийг түдгэлзүүлж, хүчингүй болгож, дуусгавар болгож байсан бол энэ талаар бичиж шалтгааныг нь тайлбарлана. - Мэргэжлийн холбоо, байгууллагад эрхэлж байсан албан тушаалын нэр, огноог бичнэ. 	Монголын Хуульчдын холбооны гишүүн /түдгэлзсэн/
14	<p>Хэвлүүлсэн бүтээл болон олон нийтэд өгсөн мэдээлэл</p> <ul style="list-style-type: none"> - Өөрийн боловсруулсан, хянасан ном, өгүүлэл, тайлан, шийдвэр, зөвлөмж зэрэг аливаа хэлбэрээр хэвлүүлсэн материал байгаа бол гарчиг, хэвлэсэн газар, огноог бичнэ. - Өөрийн харьяалагддаг байгууллагын нэрийн өмнөөс бэлдсэн, эсхүл бэлдэхэд оролцсон аливаа хууль тогтоомж, дүрэм журам, шийдвэр, тайлан, зөвлөмж болон бусад материал байгаа бол түүнийг хэвлэсэн байгууллагын нэр, хаяг, огноо, гол агуулгыг бичнэ. - Лекц, илтгэл, нээлтийн үг зэрэг илтгэл, яриа, огноо болон газрыг зааж, энэ талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр цацагдсан бол энэ тухай бичнэ. Хэрэв илтгэл, ярианы хуулбарыг хийх боломжгүй бол түүнийг зохион байгуулсан байгууллагын нэр, хаяг, илтгэл, ярианы огноо, товч агуулгыг бичнэ. - Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсааж бичнэ. Ярилцлагуудын огноог зааж, боломжтой бол ярилцлагын 	<p>“Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бус, хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц” сэдэвт хууль эрх зүйн орчин нөхцөлийг сурталчилсан гарын авлага 350 ширхэг, зурагт хуудас 200 ширхэгийг хэвлүүлэн иргэн аж ахуйн нэгж байгууллагад хүргэх нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулсан.</p> <p>Хүний эрхийг хангах, эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр иргэдтэй хэрцгий, хүнлэг бус, хүний нэр төрийг доромжлон харьцахгүй байх чиглэлд анхаарч, мэдүүлэг авах 5 өрөөг Улсын ерөнхий прокурорын 2017 оны 06 дугаар сарын 27-ны өдөр батлагдсан А/57 дугаар тушаалаар баталсан “Мэдүүлэг авах өрөөнд тавигдах шаардлага”-ын дагуу тохижуулан засварлаж, Нийслэлийн Прокурорын газраас зөвшөөрлийг авч, үйл ажиллагаандаа ашиглаж байна.</p> <p>Дүүргүүд дэх цагдаагийн газар хэлтсийн мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий алба хаагчдын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, эрүү шүүлтээс ангид байх чиглэлээр доорх сэдвүүдээр сургалт зохион байгуулахаар төлөвлөн “Цагдаагийн байгууллагын удирдах ажилтны манлайлал, түүний хэв шинж, арга барил”, “Эрүү шүүлтээс ангид байх эрхийн хэрэгжилт”, “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа”, “Эрүү шүүлтийн өнөөгийн нөхцөл байдал” зэрэг сургалтын материалыг бэлтгэн, “Монгол улсын хүний эрхийн үндэсний комиссоос гаргасан “Хүний эрх ба эрүү шүүлт” номыг нийт алба хаагчдад уншиж судлуулан сургалт зохион байгуулж ажилласан байна.</p>

	тэмдэглэл, дүрс бичлэгээс хуулбарлан өгнө.	
--	--	--